ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДЫН ТОО БҮРТГЭЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ (2005-2008)

К. Пүрэвсүрэн

Төрийн албан хаагчдын талаарх тоо бүртгэл, төрийн албанд шинээр нэмэгдсэн орон тоо, тэдгээрт зарцуулагдах төсвийн зардлын хэмжээг холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэл, судалгаанд тулгуурлан нэгтгэн гаргах боломжгүй байна. Учир нь улсын хэмжээнд нийт 4000 орчим төрийн байгууллага байдаг ба тооллогыг явуулах аргачлал нь төрийн албан хаагчийн ангилал зэрэглэл болон яам, агентлагийн гэх мэт салбар чиглэлээр нь бүртгэлийг багцалж гаргадаг тухай Төрийн албаны зөвлөлөөс тайлбар өгсөн болно

Төрийн албан хаагчийн тоо бүртгэлийн явцад зарим байгууллагыг толгой байгууллагынх нь нэгжид хамааруулан тоолсон ба энэ нь ТЕГ-ын харьяа Улсын бүртгэлийн албанаас олгосон Улсын бүртгэлийн дугаар бүхий гэрчилгээтэй, бие даасан хуулийн этгээдүүдийг төрийн байгууллага хэмээн үзсэн ба харин зарим яамны нэгж байгууллага нь бие даасан хуулийн этгээд гэх боловч Улсын бүртгэлийн өөрийн дугааргүй учир Төрийн байгууллага гэж үзээгүй дээд байгууллагынх нь нэгэн нэгж гэж үзсэн байна. Мөн зарим нууцын зэрэглэлтэй байгууллага тоон бүртгэлд хамрагдаагүй тул нийт төрийн байгууллагын тоог ойролцоогоор 4000 гэсэн болно.

Мөн төрийн албан хаагчдын дунд өөр албан ажлыг хавсран гүйцэтгэх явдал багагүй байдаг нь бодит тоог хүн нэг бүрээр гаргахад хүндрэлтэй байдаг байна. Цалингийн сангийн талаарх мэдээллийг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуулийн дагуу төсөв ерөнхийлөн захирагчийн багцанд тусгасан төсвөөс авч нэгтгэсэн болно Дашрамд дурдахад Өдрийн сонинд нийтлэгдсэн Төрийн албан хаагчдын тоо 10.0 мянгаар зөрсөн тухайд тодруулга хийсэн ба энэ нь дээр дурдсан давхар ажил эрхлэлт болон хүчний байгууллагын албан хаагчдын тоотой холбоотой бөгөөд Сангийн яамнаас албан хаагчийн тоог гаргахдаа цалинждаг тоогоор гаргасан байдаг нь дээрх хоёр байгууллагын тоон үзүүлэлт зөрүүтэй болоход хүргэсэн байна.

Төрийн албан хаагчдын орон тооны өөрчлөлтийн талаар Төрийн албаны зөвлөлөөс санал авах тухай Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8-т “төрийн байгууллагын өөрчлөлт, хөгжлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хүний нөөцийн төлөвлөлтийн арга зүй, удирдлагаар хангах, …” мөн зүйлийн 35.1.11-т “төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг боловсруулан батлахад санал өгөх, төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийхэд мэргэшил арга зүйн зөвлөгөөгөөр хангах” гэж заасан боловч төрийн захиргааны байгууллагын бүтэц зохион байгуулалт, орон тооны өөрчлөлтийн шийдвэрийг Засгийн газар, Улсын Их Хурал хуулийн дагуу Төрийн албаны зөвлөлөөс санал авахгүйгээр гаргадаг байна.

Үүнтэй холбоотой төрийн албан хаагчдын шилжилт хөдөлгөөн гарах үед тухай бүрт нь мэдээллийг авч чаддаггүйгээс төрийн албан хаагчдийн орон тооны өөрчлөлтийн нарийвчилсан тоон мэдээлэл тэр бүр гардаггүй ба зөрүүтэй байдаг тухай Төрийн албаны зөвлөлийн мэргэжилтэн тайлбарлав. Дараах багцаар гаргасан мэдээллийг Төрийн албаны зөвлөл, Үндэсний статистикийн газраас авсан мэдээ, материалд тулгуурлан гаргасан болно. Иймд олдсон мэдээлэл болон Монгол Улсын 2006 – 2008 оны төсөв, төсвийн гүйцэтгэлийн тайланд тулгуурлан төрийн албан хаагчдын тоо, цалингийн сангийн өсөлтийн талаар зарим үзүүлэлтийг хавсралт хүснэгтээр нэгтгэн гаргав.

* * *

Эмхэтгэл - 2

ЯАМД, АГЕНТЛАГИЙН 2006-2008 ОНЫ ОРОН ТООНЫ ТОЙМ ҮЗҮҮЛЭЛТ

Хавсралт 1

Төрийн байгууллага		2006 он		2007 он		2008 он	
		Орон тоо	Өсөлт, бууралт	Орон тоо	Өсөлт, бууралт	Орон тоо	Өсөлт, бууралт
Яамд	Гадаад хэрийн яам	397		540	+ 143	540	0
	Санхүү, гааль татвар	2389		2697	+ 308	2697	0
	ХЗДХЯ	15743		2727	-13016	18625	+15898
	Байгаль орчны яам	2246		2564	+318	2564	0
	Батлан хамгаалах яам	7290		674	-6616	9606	+8932
	БСШУЯам	50078		58074	+7996	58329	+255
	Барилга, хот байгуулалтын яам	440		939	+499	939	0
	ЗТАЖЯам	88		194	+106	194	0
	Түлш, эрчим хүчний яам	56		95	+39	113	+18
	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	2384		103	-2281	2023	+1920
	Үйлдвэр худалдааны яам	268		325	+57	325	0
	ХХААЯам	549		570	+21	570	0
	Эрүүл мэндийн яам	20466		24653	+4187	24635	0
Агентлаг	Улсын мэргэжлийн хяналтын газар	1437		1661	+224	1661	0
	Онцгой байдлын Ерөнхий газар	2537		3135	+598	3135	0

Тайлбар: 2005 онд яамдын харьяаллаар нарийвчлан гаргасан бүртгэлийг ТАЗ-өөс ирүүлэгүй ба ҮСГ-аас болон бусад эх сурвалжаас хайхад уг мэдээлэл олдоогүй тул тухайн онд бүртгэгдсэн нийт төрийн албан хаагчийн тоог оруулав. 2005 оны тайлан мэдээ байхгүйгээс 2006 оны өсөлт, бууралтыг тооцоогүй болно.

ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН 2005-2008 ОНЫ ЦАЛИНГИЙН САНГИЙН ТОЙМ ҮЗҮҮЛЭЛТ

Хавсралт 2

Төрийн байгууллага		2005 он	2006 он	2007 он	2008 он
		Цалингийн сан /мян.төг/[1]	цалингийн сан /сая. төг/	цалингийн сан /сая. төг/[2]	цалингийн сан /сая. төг/[3]
МУ-ын Ерөнхийлөгчийн ТГ-ын даргын төсөвийн багц			126.0 /үндсэн цалин/	1,611.0	1,840.9
УИХ-ын ТГ-ын ЕНБДарга		466,899.3	649.4	1,002.8	2,390.5
Ерөнхий сайд		3,319,204.4	3,120.1	4,373.7	8,381.3
ЗГХЭГ-ын дарга		804,679.5	884.2	1,600.1	2,832.2
Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч		114,053.7	174.36	228.05	507.5
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга		1,444,990.7	2,019.2	2,639.5	6,381.9
Улсын ерөнхий прокурор		1,019,981.6	1,388.2	1,880.6	4,160.5
Яамд	Гадаад хэргийн сайд	3,787,703.1	4,054.8	5,093.4	7.446.5
	Сангийн сайд	3,700,160.0	5,052.1	6,800.5	14,260.8
	ХЗДХэргийн сайд	18,684,854.0	26,863.3	34,908.5	68,823.5
	Байгаль орчны сайд	1,970,477.3	2723.9	3901.9	9198.7
	Батлан хамгаалахын сайд	9,791,183.3	13,930.5	18,205.5	34,609.7
	БСШУ-ны сайд	52,950,586.3	53,267.40	Байхгүй	Байхгүй
	Барилга, хот байгуулалтын сайд	465,463.9	687.3	1448.9	3272.1
	ЗТАЖ-ын сайд	110,433.5	174.6	253.1	2,953.8
	Түлш, эрчим хүчний сайд	157,490.3	237.1	288.8	1,369.1
	НХХөдөлмөрийн сайд	872,822.7	871.7*	Байхгүй	Байхгүй
	Үйлдвэр, худалдааны яам	480,987.6	956.6	1119.9	2288.1
	ХХАА-н сайд	606,456.6	835.0	1,048.1	3,098.6
	Эрүүл мэндийн сайд	24,194,619.2	33437.27	42152.35	96836.06

Агентлаг	Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайд	1,991,838.5	2,932.3	3,944.2	7082.7
	Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд	3,969,964.5	5,664.50	7,948.90	14,976.04

* * *

Тайлбар: УИХ-д ажлаа тайлагнадаг зарим байгууллагууд болон агентлагуудын талаарх хүснэгт дэх мэдээлэл ашигласан материалд бүрэн тусгагдаагүй байх тул яамд, УИХ-д ажлаа тайлагнадаг зарим байгууллагын түвшинд мэдээллийг гаргав.

(Footnotes)

[1] Монгол Улсын 2005 оны төсвийн гүйцэтгэлийн хураангуй тайлан 2006 он
[2] Монгол Улсын 2008 оны төсвийн төсөл
[3] Монгол Улсын 2008 оны төсвийн төсөл
[4] Монгол Улсын Төрийн албан хаагчийн 2007 оны тоо бүртгэл